БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2023/129/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын<br>дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Х.Манаргүл<br>Утас: 95429524 Цахим хаяг: manargulx@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ **Error! Bookmark not defined.**

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ **Error! Bookmark not defined.**

4.1 Ерөнхий зүйл ........ **Error! Bookmark not defined.**

4.2 Материаллаг байдал ........ **Error! Bookmark not defined.**

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ **Error! Bookmark not defined.**

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... **Error! Bookmark not defined.**

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ **Error! Bookmark not defined.**

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ **Error! Bookmark not defined.**

4.5.1 Завсрын аудитын талаар ........ **Error! Bookmark not defined.**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ **Error! Bookmark not defined.**

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ **Error! Bookmark not defined.**

5.1 Төлбөрийн акт ........ **Error! Bookmark not defined.**

5.2 Албан шаардлага ........ **Error! Bookmark not defined.**

5.3 Зөвлөмж ........ **Error! Bookmark not defined.**

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ **Error! Bookmark not defined.**

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2023.02.20 № 118
танай ____________ -ны № ____________ -т

ӨЛГИЙ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 8 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.АРМАНГУЛ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг зохих журмаар хийгээгүй, хөрөнгийн үлдэгдлийг бүрэн баталгаажуулаагүй.
2. Няравын бараа материалын тайланг зохих журмын дагуу гаргаж тооцоо хийгээгүй, санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, нягтлан бодох бүртгэлийн журналуудыг хөтлөөгүй, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.2.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.4, -д 14.4.1, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.6 дах заалтууд,

Дүгнэлт-Өлгий 8-р сургууль-2.22-ТА.doc8

УСНББОУС 1 стандартуудад нийцэхгүй, иж бүрэн байх, толилуулга, оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сургуулийн 2022 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлог асуудал байхгүй байна.

**Аудитын гол асуудал**

Төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

Дүгнэлт-Өлгий 8-р сургууль-2.22.doc8

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,629,017.00** | **29,479,007.16** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 24,591,990.16 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 24,591,990.16 |
| **3121** | **Төгрөг** | - | 24,591,990.16 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | - | 24,591,990.16 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 3,629,017.00 | 4,887,017.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 3,629,017.00 | 4,887,017.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 2,533,400.00 | 2,533,400.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | 234,000.00 |
| 35460 | Хүнсний материал | - | 244,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,095,617.00 | 1,875,617.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **59,489,966.83** | **79,263,233.84** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 59,489,966.83 | 79,263,233.84 |
| **392** | **Биет хөрөнгө** | 58,942,566.83 | 78,715,833.84 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 38,185,614.00 | 38,185,614.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (2,566,360.70) | (3,933,501.02) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 27,986,715.00 | 55,778,715.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (16,535,833.05) | (21,450,768.27) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9,648,644.00 | 9,648,644.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (6,044,415.17) | (7,000,023.87) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 3,312,050.00 | 3,312,050.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (2,382,321.25) | (3,163,370.00) |
| 39217 | Ном | 7,338,474.00 | 7,338,474.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 547,400.00 | 547,400.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (550,000.00) | (550,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 547,400.00 | 547,400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **63,118,983.83** | **108,742,241.00** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **63,118,983.83** | **108,742,241.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 63,118,983.83 | 108,742,241.00 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 37,821,898.00 | 37,821,898.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 37,821,898.00 | 37,821,898.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 14,753,925.11 | 60,377,182.28 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 14,753,925.11 | 14,753,925.11 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 45,623,257.17 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 10,543,160.72 | 10,543,160.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **63,118,983.83** | **108,742,241.00** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **207,790,313.00** | **307,212,400.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **(2,317,400.00)** | **-** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **(2,317,400.00)** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | (2,317,400.00) | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **210,107,713.00** | **307,212,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 199,514,300.00 | 281,273,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 259,150,800.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | - | 22,123,000.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 199,514,300.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,407,013.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,407,013.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 6,186,400.00 | 25,938,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 6,186,400.00 | 25,938,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **199,349,072.52** | **261,589,142.83** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **199,349,072.52** | **261,589,142.83** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 202,046,072.52 | 241,373,092.02 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 161,611,310.00 | 192,927,344.00 |
| 210101 | Үндсэн цалин | 142,049,678.00 | 158,190,204.53 |
| 210102 | Нэмэгдэл | - | 31,787,443.09 |
| 210104 | Урамшуулал | 11,575,432.00 | 2,949,696.38 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,986,200.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21,161,582.00 | 24,115,918.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,849,621.00 | 15,728,718.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,578,290.00 | 2,046,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,262,612.00 | 1,690,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 314,978.00 | 422,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,156,081.00 | 4,227,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 7,586,200.00 | 9,809,900.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,103,400.00 | 750,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 4,274,500.00 | 6,559,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,208,300.00 | 2,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,735,100.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 79,900.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,400,000.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 695,000.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | 114,200.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 100,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 346,000.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 261,500.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 33,100.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 228,400.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.00 | 900,850.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 651,050.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 249,800.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 91,300.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 91,300.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,164,200.00 | 1,602,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 764,200.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,602,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 5,934,880.52 | 12,016,180.02 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 65,000.00 | 1,454,547.03 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,566,900.00 | 2,542,900.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 4,302,980.52 | 8,018,732.99 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | (2,697,000.00) | 20,216,050.81 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,303,000.00 | 20,216,034.81 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 7,303,000.00 | 15,416,170.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 4,799,864.81 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 16.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 16.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | (10,000,000.00) | - |
| 213501 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | (10,000,000.00) | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **8,441,240.48** | **45,623,257.17** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **8,441,240.48** | **45,623,257.17** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Тайлант оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **210,107,713.00** | **285,089,400.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **210,107,713.00** | **285,089,400.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 199,514,300.00 | 259,150,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 259,150,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 199,514,300.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 4,407,013.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 4,407,013.00 | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 6,186,400.00 | 25,938,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 6,186,400.00 | 25,938,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **206,457,713.00** | **254,828,409.84** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **206,457,713.00** | **254,828,409.84** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **194,593,692.00** | **237,639,393.84** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 162,792,792.00 | 191,694,104.84 |
| 210101 | Үндсэн цалин | 143,231,160.00 | 149,633,344.46 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | | 38,173,760.38 |
| 210104 | Урамшуулал | 11,575,432.00 | 3,887,000.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 7,986,200.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 19,380,500.00 | 24,115,918.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,638,500.00 | 15,661,418.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,435,400.00 | 2,114,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,148,600.00 | 1,690,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 286,900.00 | 422,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,871,100.00 | 4,227,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 5,686,400.00 | 9,490,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 874,400.00 | 1,374,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 2,812,000.00 | 5,616,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,000,000.00 | 2,500,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,735,100.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 79,900.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,400,000.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 695,000.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | 114,200.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 100,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 346,000.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 261,500.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 33,100.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 228,400.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 91,300.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 91,300.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,164,200.00 | 1,511,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 764,200.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 400,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 1,511,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 981,900.00 | 10,327,171.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 7,932,471.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 981,900.00 | 2,394,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,864,021.00** | **17,189,016.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 7,303,000.00 | 17,189,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 7,303,000.00 | 13,560,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 3,628,800.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,561,021.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,561,021.00 | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 16.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 16.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **3,650,000.00** | **30,260,990.16** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **3,650,000.00** | **5,669,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,650,000.00** | **5,669,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 3,650,000.00 | 5,669,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,650,000.00 | 5,669,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(3,650,000.00)** | **(5,669,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 24,591,990.16 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 24,591,990.16 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооний нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **37,821,898.00** | **10,543,160.72** | **14,753,925.11** | 63,118,983.83 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **37,821,898.00** | **10,543,160.72** | **14,753,925.11** | 63,118,983.83 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **37,821,898.00** | **10,543,160.72** | **14,753,925.11** | 63,118,983.83 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 45,623,257.17 | 45,623,257.17 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **37,821,898.00** | **10,543,160.72** | **60,377,182.28** | 108,742,241.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 285,089,400.00 | 260,497,393.84 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 285,089,400.00 | 260,497,393.84 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 267,900,400.00 | 243,308,393.84 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 211,534,000.00 | 191,694,104.84 |
| 210101 | Үндсэн цалин | 164,634,700.00 | 149,633,344.46 |
| 210102 | Нэмэгдэл | 43,012,300.00 | 38,173,760.38 |
| 210104 | Урамшуулал | 3,887,000.00 | 3,887,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 26,420,900.00 | 24,115,918.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,966,400.00 | 15,661,418.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,114,000.00 | 2,114,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,690,900.00 | 1,690,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 422,400.00 | 422,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,227,200.00 | 4,227,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 9,490,400.00 | 9,490,400.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,374,400.00 | 1,374,400.00 |
| 210302 | Түлш, халаалт | 5,616,000.00 | 5,616,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 500,000.00 | 500,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 | 500,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,511,800.00 | 1,511,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,511,800.00 | 1,511,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,443,300.00 | 15,996,171.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,048,600.00 | 13,601,471.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,394,700.00 | 2,394,700.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 17,189,000.00 | 17,189,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 17,189,000.00 | 17,189,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 13,560,200.00 | 13,560,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,628,800.00 | 3,628,800.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 285,089,400.00 | 285,089,384.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 259,150,800.00 | 259,150,800.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 259,150,800.00 | 259,150,800.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 25,938,600.00 | 25,938,584.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 25,938,600.00 | 25,938,584.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 24,591,990.16 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тус байгууллагад нэмэлт данс байхгүй байна

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь бага боловсрол олгох чиг үүргийг хэрэгжүүлдэг байгууллага ба "Хүүхэд нэг бүрийг хөгжиж төлөвших эрүүл таатай орчин бүрдүүлэх эвсэг бүтээлч хамт олон болох” зорилт дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь үйл ажиллагаандаа Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж иргүүлээгүй байна.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь НББ-ын бодлогын баримт бичиг боловсруулж ажиллаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45.6 сая төгрөгөөр буюу 72.2 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 24,592.0 | 24,592.0 |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 3,629.0 | 4,887.0 | 1,258.0 |
| Үндсэн хөрөнгө | 59,490.0 | 79,263.2 | 19,773.3 |
| **Нийт хөрөнгө** | **63,119.0** | **108,742.2** | **45,623.3** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 63,119.0 | 108,742.2 | 45,623.3 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **63,119.0** | **108,742.2** | **45,623.3** |

Дээрх хүснэгтээс харахад дараах данснуудад нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 24.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 4.9 сая төгрөг болж 1.2 сая төгрөгөөр өссөн. Төсвийн хөрөнгөөр 27.9 сая төгрөгийн бараа материалыг худалдан авч, 26.6 сая төгрөгийг үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 79.3 сая төгрөг болж 19.7 сая төгрөгөөр өссөн нь 5.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, “Санко Маркетинг монголия ХХК”-аас 22.1 сая төгрөгийн машин тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Тайлант онд 45.6 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 45.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 280.8 сая, нийт зарлагыг 280.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 4.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 285.1 сая төгрөгөөр баталсан байна.

Төсвийн төслийн саналаас цалин, НДШ-ийн зардал 3.6 сая, хангамж бараа материалын зардлыг 1.3 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1.6 сая, норматив зардал 0.4 сая, эд хогшил урсгал зардал 2.0 сая, томилолт, зочны зардал 0.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 0.4 сая төгрөгөөр бууруулж, харин бараа үйлчилгээний бусад зардал 7.9 сая, урсгал шилжүүлэг 6.1 сая төгрөгөөр тус тус нэмэгдэж бүгд 4.3 сая төгрөгөөр нэмж, нийт зардлыг 285.1 сая төгрөгөөр баталсан байна.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2022 оны анх батлагдсан төсөв 279.3 сая төгрөг ба тодотгосон төсөв 285.1 сая төгрөг байна. Тодотгосон төсөв нь анх баталсанаас 5.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх Ерөнхий боловсрол гэсэн 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 259.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 25.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүгд 285.1 сая төгрөгийг санхүүжүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 259.2 сая, орон нутгийн төсвөөс 25.9 сая бүгд **285.1** сая төгрөгийн санхүүжилт олгож гүйцэтгэл 100 хувьтай байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 91.4 хувь 260.5 сая төгрөг ба хэмнэгдсэн 24.6 сая төгрөгийг байгууллагын харилцах дансны үлдэгдэлд байна.

Төсвийн гүйцэтгэлийг зардал бүрээр задалж харуулахад цалин хөлс болон нэмэгдэл урамшил зардал 190.0 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 26.4 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 9.5 сая, эд хогшил, урсгал засварын зардал 0.5 сая, бусад бараа үйлчилгээний зардал 1.5 сая, бараа үйлчилгээний бусад зардал 15.4 сая, урсгал шилжүүлэг 17.2 сая бүгд 260.5 сая төгрөг байна.

Нийт төсвийн зарлагын 72.4 хувийг цалингийн зардал, 10.1 хувийг нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3.6 Хувийг, эд хогшил, урсгал засварын зардал 0.1 хувийг, бараа үйлчилгээний бусад зардал 13.8 хувийг эзэлж байна.

Тайлант онд дараах хөтөлбөрүүдээс нийтдээ 24.5 сая төгрөг хэмнэгдэсэн байна. Үүнд: байр ашиглалтын үйлчилгээ 0,03 сая, хүүхдэд ээлтэй сургалтын орчин 3.0 сая, боловсролын стандарт, сургалт 15.4 сая, сургалтын хэвийн үйл ажиллагаа 6.1 сая төгрөг тус тус хэмнэгдсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Байр ашиглалтын үйлчилгээ | 284.0 | 255.6 | (28.4) | 90% |
| 2 | Сургалт семинар | 142.0 | 142.0 | - | 100% |
| 3 | Эрүүл мэндийг дэмжих | 684.2 | 684.2 | - | 100% |
| 4 | үдийн цай хөтөлбөр | 13,560.2 | 13,560.2 | - | 100% |
| 5 | Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 7,495.0 | 4,495.0 | (3,000.0) | 60% |
| 6 | Боловсролын байгууллагын багш, | 1,379.4 | 1,379.4 | - | 100% |
| 7 | Боловсролын стандарт, сургалты | 183,603.6 | 168,226.2 | (15,377.4) | 92% |
| 8 | Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 52,002.4 | 45,816.2 | (6,186.2) | 88% |
| 9 | Нийтлэг үйлчилгээ | 25,938.6 | 25,938.6 | - | 100% |
| | **Дүн** | **285,089.4** | **260,497.4** | **(24,592.0)** | **91%** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилт аваагүй байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий ймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Манаргүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 210.3 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой төсвийг хэмнэх талаар 29 арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 зүйлийн 15.2.1-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх” гэж заасныг хангаж ажилаагүй ба хэрэгжүүлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль нь 2022 онд нийт 786.7 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас шилэн

дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75% байна. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг байршуулаагүй байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн төсвийн зарцуулалт нь Төсвийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Өлгий сумын Ерөнхий боловсролын 8 дугаар сургууль 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудит хийгдээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн мэдээ, мэдээллийг хугацаандаа байршуулаагүй зөрчил арилгах 1 албан шаардлага өгсөн ба ш илэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлийг давтан гаргасан байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант онд 3 нягтлан бодогч ажилласан ба анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтнгүй байна. Дараагийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг зохих журмын дагуу хөтөлсөн эсэхд анхаарал хандуулах шаардалагатай байна. Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалж сургуулийн төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй, санхүүгийн тайлан гаргалтыг шалгаж баталгаажууллаа.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 4.1 сая төгрөгийн алдаа илэрч залруулга хийсэн. Цалингийн зардлыг 4.1 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулав.

Аудитаар нийт 149.6 сая төгрөгийн зарчил илэрч 2.0 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 116.2 сая төгрөгийн зөрчилд сахилгын шийтгэл ногдуулах 2 албан шаардлага, 31.4 сая төгрөгийн 4 зөвлөмж өгөв.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар 2.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Цалингаас нийтдээ 13.9 сая төгрөгийн татвар ногдуулан суутгаж үүнээс 12.7 сая төгрөгийг төсөвт шилжүүлж, 1.2 сая төгрөгийг төсөвт дутуу шилжүүлж, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаж харуулаагүйд нөхөн төлүүлэх акт тогтоов.
2. Сургуулийн нягтлан бодогчид хүний нөөцийн ажил хавсран гүйцэтгэсэн нэрийдлээр цалингийн 40 хувиар 0.8 сая төгрөгийн нэмэгдэл олгосныг нөхөн төлүүлэх акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар 116.2 сая төгрөгийн зөрчилд 3 албан тушаалтаннд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага өгөгдлөө.Үүнд:

1. Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг зохих журмаар хийгээгүй, хөрөнгийн үлдэгдэлиг баталгаажуулаагүй.

2. Нярав нь агуулахын бүртгэл хөтлөөгүй, бараа материалын тайланг зохих журмын дагуу гаргаж тайлагнаагүй, нягтлан бодогч нь нягтлан болох бүртгэлийг зохих журмаар хөтлөөгүй, санхүүгийн анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй, төсвийн зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй.
3. Үдийн хоолонд 15.4 сая төгрөгийг зарцуулсан боловч санхүүгийн баримтыг эмх цэгцгүй үдсэнээс тооцоо хийх, тулган шалгах боломжгүй.
4. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 19.8 сая төгрөгийн 8 шийдвэр гарсныг мэдээлээгүй, шилэн дансны мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 75.0 %, өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд зөрчлийг давтан гаргасан.

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Сургууль нь хоёр жижиг зуухтай мөртлөө сард 10-аад тонн, жилд 80 гаруй тонн нүүрс хэрэглэж, түлш, халаалтын зардалд 5.6 сая төгрөг зарцуулсан.

*1.1 Өгсөн зөвлөмж:*

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 зүйлийн 15.2.1-д “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх” гэсэн заалтыг мөрдөн ажиллах.

***2.Үндсэн хөрөнгийн үнэлгээтэй холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой 55 нэр төрлийн 23.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.

*2.2 Өгсөн зөвлөмж:*

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох”, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэсэн заалтыг мөрдөж, ээлэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн цаашид ашиглах боломжтой үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох.

***3. Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэхтэй холбоотой асуудал***

*3.1. Илрүүлэлт:*

Албан томилолт, нормын хувцас, сургалтын төлбөр зэрэг зардлуудын 1.9 сая төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

*3.2 Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг бэлтгэх заавар аргачлалын хэрэгжилтийг хангаж ажиллах.

4. ***Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэхтэй холбоотой асуудал***

*4.1. Илрүүлэлт:*

Сургууль нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж ажиллаагүй байна.

*4.2 Өгсөн зөвлөмж:*

Холбогдох стандартын шаардлага хангасан, байгууллагын онцлог, үйл ажиллагааг тусгасан, нягтлан бодох бүртгэл, тайлагнал, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бусад үйл ажиллагаатай уялдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, байгууллагын даргын тушаалаар баталж, ашиглах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | 1 | 4128.0 | | | | | 1 | 4128,0 | | | | |
| | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Суутгасан татварыг төсөвт дутуу шилжүүлсэн | 1 | 1233.2 | 1 | 1233.2 | | | | | | | | |
| Батлагдаагүй орон тоонд хавсран гүйцэтгэсэн нэрийдлээр цалин олгосон | 1 | 847.8 | 1 | 847.8 | | | | | | | | |
| Тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж | 1 | 1939.0 | | | | | 1 | 1939.0 | | | | |
| Нягтлан бодох | 2 | 96381.2 | | | | | | | 2 | 96381.2 | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| бүртгэлтэй холбоотой | | | | | | | | | | | | |
| Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн үнийг зохих журмын дагуу шинэчлэн тогтоогоогүй | 1 | 23853.4 | | | | | 1 | 23853.4 | | | | |
| НБББББ боловсруулж ажиллаагүй байна. | 1 | 0.0 | | | | | 1 | 0.0 | | | | |
| **Дүн** | **7** | **124254.6** | **2** | **2081.0** | | | **3** | **25792.4** | **2** | **96381.2** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй | 1 | 19869.3 | | | 1 | 19869.3 | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **19869.3** | | | **1** | **19869.3** | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Түлш, халаалтын зардалд | 1 | 5616.0 | | | | | 1 | 5616.0 |
| Дүн | 1 | 5616.0 | | | | | 1 | 5616.0 |
| **Нийт дүн** | **2** | **25485.3** | | | **1** | **19869.3** | **1** | **5616.0** |